



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2007 оны 4 сарын 4 өдөр

Дугаар 139

Улаанбаатар хот

**Хөдөлмөрийн биржийн талаар авах  
зарим арга хэмжээний тухай**

"Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" Монгол Улсын хуулийн 29 дүгээр зүйлийн 1.5-ийн "д", "Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтцийг тогтоох тухай" Засгийн газрын 2005 оны 15 дугаар тогтоолын 8 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. "Нийслэлийн Хөдөлмөрийн бирж"-ийн бүтэц, орон тоог нэгдүгээр, дүрмийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Нийслэлд ажлын байр нэмэгдүүлэх, гадаадад ажиллах хүч гаргах зорилтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Хөдөлмөрийн биржийн үйл ажиллагааг эхлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 28.0 сая /Хорин найман сая/ төгрөгийг нөөц сангаас гаргахыг Тамгын газар /Ц.Болдсайхан/-т зөвшөөрсүгэй.

Гурав. Нийслэлийн Хөдөлмөрийн биржийн үйл ажиллагаа явуулах ажлын байрны асуудлыг шийдвэрлэхийг Өмчийн харилцааны газар /М.Ганбаатар/-т үүрэг болгосугай.

Дөрөв. Нийслэл хот гадаадад ажиллах хүч гаргах зөвшөөрлийг холбогдох яамнаас авах, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санг 2007 оны төсвийн тодотголоор зохих журмын дагуу байгуулж батлуулах асуудлыг шийдвэрлүүлэхийг Засаг даргын орлогч Б.Баатарзориг, Хөдөлмөрийн бирж /Б.Батбаатар/, Санхүү эдийн засаг, төрийн сангийн хэлтэс /Д.Ганболд/-т тус тус даалгасугай.

Тав. Нийслэлд "Ажлын байр нэмэгдүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх" жилийн хүрээнд 2007 онд 40000 ажлын байр бий болгох зорилт дэвшүүлсэнтэй холбогдуулан нийслэл, дүүргийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын албадын ажлын уялдаа холбоог өргөжүүлэн ажиллахыг Нийгмийн хөгжлийн хэлтэс /Д.Энхбаяр/, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын газар /М.Уламбаяр/, Хөдөлмөрийн бирж /Б.Батбаатар/-д тус тус үүрэг болгосугай.

Зургаа. Энэ захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын орлогч Б.Баатарзоригт даалгасугай.

Долоо. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын "Хөдөлмөрийн бирж байгуулах тухай" 2005 оны 313 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт, тавдугаар заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ


Ц.БАТБАЯР

Zaki-2007  
0200562



Нийслэлийн Засаг даргын 2007 оны 4 дүгээр сарын 4-ны өдрийн 139 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

## ХӨДӨЛМӨРИЙН БИРЖИЙН БҮТЭЦ ОРОН ТОО



Нийслэлийн Хөдөлмөрийн бирж нь 10 орон тоотой ажиллана.



Нийслэлийн Засаг даргын 2007 оны  
4 дүгээр сарын 4-ны өдрийн  
139 дугаар захирамжийн  
хоёрдугаар хавсралт

## НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨРИЙН БИРЖИЙН ДҮРЭМ

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Нийслэлийн “Хөдөлмөрийн бирж” /цаашид “бирж” гэх/ нь нийслэлийн хэмжээнд хөдөлмөрийн зах зээлийн харилцааг зохицуулж ажил хайгч иргэн, ажил олгогч тэдгээрт үйлчлэгч байгууллага, хувь хүмүүст нийслэлийн төр, захиргааны байгууллагын нэрийн өмнөөс үйлчилгээ үзүүлэх, хамтран ажиллах үйл ажиллагааг эрхлэх төрийн үйлчилгээний байгууллага байна.

1.2. Бирж нь хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдлийг бууруулах үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийн зорилтыг удирдлага болгон ажиллана.

1.3. Бирж нь хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн ба төрийн бус байгууллагууд, бусад олон улсын байгууллага болон сангийн мэргэжил арга зүй, төсөв, санхүүгийн дэмжлэг туслалцаанд тулгуурлан ажиллана.

1.4. Нийслэлийн Засаг дарга нь Биржийн захирлыг томилж, чөлөөлөх бөгөөд Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн биржийн орон тоо, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон асуудлыг шийдвэрлэнэ.

### **Хоёр. Биржийн үндсэн үүрэг**

2.1. “Хөдөлмөрийн тухай”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай”, “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай”, “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор хөдөлмөр эрхлэхтэй холбогдсон харилцааны үйл ажиллагааны хэрэгжилтийг зохион байгуулна.

2.2. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтэд судалгаа дүгнэлт хийж, хөдөлмөрийн зах зээлийн чиг хандлага, төлөв байдлыг тодорхойлон ажиллана.

2.3. Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн бодлогыг хэрэгжүүлж, иргэдийн хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэх, ажиллах хүчний эрэлт нийлүүлэлтийг оновчтой зохицуулах, ажиллах хүчийг зах зээлийн эрэлтэд нийцүүлэн хөгжүүлнэ.

2.4. Ажил эрхлээгүй иргэдэд ажлын байрны талаархи мэдээлэл, мэргэжлийн болон эрх зүйн зөвлөгөө өгч, ажил олгогчдын эрэлт хэрэгцээг үндэслэн ажилд зуучлах ажлыг зохион байгуулна.

2.5. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн ажил мэргэжлээ сонгох, мэргэжлийн чиг баримжаа олгох, давтан сургалтанд хамрагдах талаар иргэдэд зөвлөгөө дэмжлэг үзүүлнэ.

2.6. Хөдөлмөр эрхлэх сонирхолтой ажилгүй болон ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэнийг бүртгэж, ажил олгогчийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн ажилд зуучлана.

2.7. Эрх бүхий мэргэжлийн сургалтын байгууллага, ажил олгогчтой хамтран иргэдийг мэргэжил олгох, давтан сургалтад хамруулах, ажил олгогчдыг дэмжих арга хэмжээг уялдуулан зохицуулна.

2.8. Хувиараа болон нөхөрлөл хоршооны хэлбэрээр хөдөлмөр эрхлэхийг хүссэн иргэдэд мэргэжлийн зөвлөгөө өгөх, аж ахуй, бизнес эрхлэх ур чадвар эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулах, ажлын байр нэмэгдүүлэх зээлийн үйлчилгээг авахад нь туслана.

2.9. Гадаадад ажиллах хүч гаргах талаархи үйл ажиллагааны хөтөлбөрийн заалтыг хэрэгжүүлэх, гэрээ хэлэлцээр байгуулах, зуучлах ажлыг "Гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай" хуулийн хүрээнд зохион байгуулна.

2.10. Ажлын байр нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэгдсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал санаачилгыг дэмжинэ.

2.11. Дүүргүүдийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийг мэргэжлийн арга зүйн удирдлагаар ханган, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төсөлд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг уялдуулан зохицуулна.

2.12. "Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн тогтолцоо"-г бий болгон мэдээллийн сүлжээнд холбох, сүлжээний техник, программ хангамжийн найдвартай ажиллагааг хангах, "Цахим-Улаанбаатар" хөтөлбөрийн хүрээнд нэгдэж, мэдээллийг ил тод нийтэд нээлттэй байлгана.

2.13. Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг боловсронгуй болгоход төрөөс дэвшүүлсэн бодлогын хэрэгжилт, төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний биелэлт, биржийн үйл ажиллагааны тайлан, мэдээг үнэн зөв гаргана.

### ***Гурав. Биржийн эрх***

3.1. Нийслэлд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамрагдах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

3.2. Нийслэлийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн талаархи мэдээ тайлан, тооцоо судалгааг аж ахуйн нэгж байгууллагаас үнэ төлбөргүй гаргуулна.

3.3. Ажилгүй иргэнийг үйлдвэрлэл дээрх сургалтад болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд сургах талаар ажил олгогч, мэргэжлийн сургалтын байгууллагуудтай гэрээ байгуулна.

3.4. Гадаадад ажиллах хүч гаргах үйлчилгээний хураамж, зээл тусламжийн хөрөнгийг өөрийн эрх хэмжээний хүрээнд холбогдох хууль, дүрмийн дагуу захиран зарцуулна.

3.5. Нийслэлийн Засаг даргаас шилжүүлсэн болон хууль тогтоомжоор олгогдсон бусад эрхийг эдлэн хариуцлага хүлээнэ.

#### ***Дөрөв. Бусад***

4.1. Биржийн дүрэмд Нийслэлийн Засаг даргын шийдвэрээр оруулсан нэмэлт өөрчлөлт нь энэхүү дүрмийн салшгүй хэсэг болно.

4.2. Биржийн үйл ажиллагааны үр дүнг нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнана.

-----oOo-----